

НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ

Оршин тогтнох нь

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.09.12, №63

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН, УЛС ТӨРИЙН
НАМААС ХАРААТ БУС ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ

Оршин тогтнох нь

НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ



ҮНДЭСНИЙ
АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ



НИЙТИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ



ЭДИЙН ЗАСГИЙН
ШИЙДВЭР ГАРГАХ

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ

Оршин тогтнох нь

Нийгмийн дэг журмыг (social order) хоёр утгаар ойлгож иржээ. Эхнийх нь, харилцах болон өөрийгөө авч явах тодорхой тогтолцоо, түүнийг бүрдүүлж, хадгалж бас сахиулж байгаа нийгмийн бүтэц, институт, харилцаа, заншил, үнэт зүйл зэргийн харилцан холбоотой систем гэж үздэг. Жишээ нь: эртний, феодалын ба капиталист нийгмийн дэг журам, эсвэл монголд бүрдүүлж буй “ардчилсан, зах зээлийн эдийн засагтай” нийгмийн дэг журам.

Нөгөөх нь, нийгмийн дэг журам алдагдах эсвэл замбараагүй байдал үүсэхийн эсрэг ойлголт буюу, нийгмийн гишүүд нь хүлээн зөвшөөрч, даган мөрдөж буй дэг журамд тулгуурлан орших нийгмийн тогтвортой байдал гэж үздэг.

“*Нийгмийн дэг журамтай улс оронд нийгэм, эдийн засаг нь хөгжиж, хүн ард нь элбэг хангалуун амьдрах боломж бүрддэг.*”

НИЙГМИЙН ДЭГ ЖУРМЫГ ХАНГАХ НЬ

Нийгмийн дэг журмыг хангана гэдэг нь улс орон өөрийн хууль журамтай, түүнийг иргэд нь даган мөрддөг байхыг хэлдэг. Нийгмийн дэг журмыг хангах нь төрийн чухал дөрвөн үүргийн нэг. Нөгөө гурав нь үндэсний аюулгүй байдлыг хангах, нийтийн үйлчилгээ үзүүлэх, эдийн засгийн шийдвэр гаргах юм.

Нийгмийн дэг журмыг хангах нь иргэдийн өдөр тутмын амьдралд чухал, эерэг нөлөөг үзүүлдэг. Нийгэм дэг журамтай байхын тулд хүн бүр хуулийг сахин мөрдөх шаардлага гардаг. Хууль зөрчсөн хэн ч гэсэн заавал хариуцлага хүлээдэг зарчим үйлчлэх ёстой. Хуулиуд нь хүний эрх, эрх чөлөөг хүндэлсэн, арьсны өнгө, эд хөрөнгө, гарал үүсэл, шашин шүтлэгээс үл хамааран, хүн бүрт ижил тэгш үйлчилдэг байх ёстой. Өөрийн газар нутаг дээр хууль сахиулах онц, бүрэн эрх зөвхөн төрд байх ёстой.

Төрийн эхний үүрэг бол баян ядуу эсэхээс үл хамааран бүх хүнд үзүүлэх нийтийн үйлчилгээ. Жишээ нь гал унтраах үйлчилгээ, цагдаа руу ярьж тусламж авах, нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх гэх мэт. Төр нь хэн нэгнийг боловсрол авах, эмнэлгийн тусламж авахыг хязгаарлах эрхгүй.

Төрийн бас нэг үүрэг бол үндэсний аюулгүй байдлыг хамгаалах буюу аль нэг улс орон, ямар нэг бүлэглэлээс иргэдийнхээ аюулгүй байдлыг хамгаалах явдал. Ил түрэмгийллээс хамгаалахын тулд зэвсэгт хүчин, далд түрэмгийллээс тагнуул, гэмт этгээдээс шуурхай хамгаалахын тулд цагдаагийн байгууллагууд ажилладаг.

Төрийн өөр нэг үүрэг бол худалдаа, бизнес, зээл авах, компаниудын үйл ажиллагаа зэрэгт нөлөөлдөг эдийн засгийн шийдвэр гаргах явдал. Санхүүгийн мэргэжилтнүүд, эдийн засгийн ►►

► зөвлөхүүд, бизнесийн удирдлагуудтай хамтран төр засаг тийм шийдвэрийг гаргадаг. Шийдвэр нь тухайн орны эдийн засгийн явц, иргэд, бизнесийн зээл авах боломжийг тодорхойлдог. Жишээ нь Төв банк зээлийн хүүгийн түвшинг тогтоодог, эсвэл Засгийн газар гадаад дотоодын зах зээлд бонд гаргадаг.

МОНГОЛЫН НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ

1992 онд ардчилсан МУ-ын анхны Их хурал ээлжит бусаар чуулж нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг баталжээ.

Нийгмийн дэг журмыг хангахын тулд хууль тогтоомжийг бүхэлд нь Үндсэн хуульд нийцүүлэн шинэчилж, нийгмийн амьдралын бүхий л хүрээнд төрийн хуулиа хүндэтгэн биелүүлдэг дэг журам тогтоохыг зорьжээ. Тэгэхдээ “төрт ёсны болон үндэсний уламжлал, зан заншлыг сэргээн хөгжүүлж, эдийн засаг, нийгэм, улс төрийн бүхий л хүрээнд хууль тогтоомжийг сахиулах, түүний дотор гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд чиглэсэн эдийн засаг, нийгэм, хууль зүйн цогцолбор арга хэмжээ авч” хэрэгжүүлнэ гэжээ.

“Тэгвэл бид 26 жилийн дараа нийгмийн дэг журмаа хангаж чадсан уу? Хууль журам бол олон л байна. ХЗДХЯ-ны мэдээлснээр Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бие даасан 449 хууль, Олон улсын гэрээ конвенци 369, Улсын Их Хурлын тогтоол 2472 гэсэн бүртгэл байдаг. Бие даасан хуулиас 300 орчим нь нийгмийн харилцааг идэвхтэй зохицуулдаг. Мөн захиргааны хэм хэмжээ тогтоосон нийтээр дагаж мөрдөх 976 шийдвэр бүртгэлтэй ажээ.”

Тэгвэл яагаад улс оронд авлига, гэмт хэрэг, замын осол жилээс жилд өсөөд байгаа юм бэ? Яагаад гэвэл тэр олон хууль журмаа монголчууд биелүүлж, хэрэгжүүлж чадахгүй байгаа юм. Хүн бүр хууль журмаа биелүүлэх ёстой гэж үзэхгүй, төр засаг ч хууль зөрчсөн хүнтэй хариуцлага тооцож чадахгүй болжээ. Монголын төр өөрөө авлигад идэгдэж зэвэрсэн учир тийм чадвараа ч алджээ.

“Нийгэм дэг журамтай байх нь сайн хуультай, түүнийг бүгд сахихаас гадна нийтийн үйлчилгээний хүртээмж ба чанар, аюулгүй байдлын баталгаа, төр засгийн эдийн засгийн шийдвэрээс ихээхэн халаарч, өөрчлөгдөж байдаг.”

Нийтийн үйлчилгээ, ялангуяа эрүүл мэнд, боловсрол, нийтийн тээвэр, хотын дэд бүтэц хэрэгцээ, шаардлагаасаа хэт хоцорч, бараг бүгд л нийгмийн дэг журмыг алдагдуулах түвшинд очоод байна. Ганц, замын түгжрэл л гэхэд түмэн олныг бухимдуулж, тэвчээрийг нь барсаар байна. Төрийн өндөрлөгүүдийн машиныг саадгүй өнгөрүүлэх гэж төв замаа чөлөөлдөг болсон нь гал дээр тос асгасаар байна.

Аюулгүй байдлыг хангах үйлчилгээ л гэхэд аюулын хонхыг хангинуулж байна. Иргэд хоолны оронд эм иддэг боллоо. Тэр эмийнх нь гуравны нэг нь хуурамч. Хилээр хэдэн мянган машин нүүрс зөөж гараад байхад гааль нь “харахгүй” байна. Хүнсний аюулгүй байдлын тухай ярихаа ч больсон.

Төрийн гаргаж буй эдийн засгийн шийдвэрүүд нь тооцоо судалгаа муу, тодорхой бүлэглэлд үйлчлээд удаж байна. Хаадын нэрээр авсан зээлийн бүтэн тайлан одоо хүртэл гараагүй, ганц хоёр хүнийг байцаасан болоод л таг. Авлигатай тэмцэхийн оронд, АТГ-ын даргатай нь тэмцэх боллоо. Үнэ тогтоох нэрээр тогтоосон бүлэглэл нь завшиж байна. Уул уурхайн салбарыг төр засгийн оронд “нинжа” нар хянаж эхэлсэн.

Нийгмийн дэг журмыг хангахын тулд хуулиа сахиулж, шударга ёсыг тогтоох учиртай. “Хууль бол шударга ёсыг тогтоох явдал”. Харин “Шударга ёс зөвхөн шударга бус нь алга болоход л ирнэ гэж Францын гүн ухаантан Ф.Бастиа бүр 170 жилийн өмнө бичжээ.

2018.09.12



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2018.09.09-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

COAL MONGOLIA 2018

Нүүрсний салбарын худалдаа, хөрөнгө оруулалтын Coal Mongolia чуулга уулзалт 8 дахь удаагаа зохион байгуулагдлаа. Нүүрсний зах зээлийн хамгийн гол импортлогч бол урд хөрш БНХАУ. Хятадад нийлүүлэх нүүрсний экспортын хэмжээгээрээ Австрали улсын араас манай улс бичигддэг. Тэгвэл энэ жилийн чуулганаар Хятадын нүүрсний зах зээлд ОХУ томоохон нөлөө үзүүлэх болсныг онцолж байсан. Энэ асуудалтай холбогдуулаад манай улсын байр суурь, өрсөлдөх чадварын талаар яригдаж байна. Уг салбарын өрсөлдөх чадвар нь дэд бүтэц буюу логистикоос ихээхэн хамааралтай байдаг. Мэдээж хурлаар ч бас нөгөө л хөндөгддөг дэд бүтцийн асуудал яригдсан.

Энэ салбарт илэн далангүй уулзаад ярих механизм хэрэгтэй байсан тэр орон зайг нөхөөд энэ үйл ажиллагааг зохион байгуулж байна. Ер нь нүүрсний бизнесийг уул уурхайн гэхээс илүүтэй логистикийн бизнес юм байна гэсэн ухаарал бий боллоо гэж зохион байгуулагчид нь онцолж байсан. Үүнээс хойш энэ чуулганыг дандаа өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тээвэр логистикийг оновчтой болгоход чиглэгдэх болно гэж хэлсэн байна. Хятадын нүүрс, тээвэр түгээлтийн холбооны ерөнхийлөгч, Хятадын үндэсний нүүрсний ассоциацийн эдийн засаг хариусан ерөнхий захирал Ян Сианфенг гэж хүн оролцсон нь онцлох үйл явдал байлаа. Энэ хүн өнөөдрийн салбарын аж байдлын тухай дэлгэрэнгүй ярьсан л даа. Мөн энэ үеэр ЭТТ компанийн хувьцааг олон улсын зах зээлд гаргана гэж хэлсэн. ЭТТ өрөө дарсан ба Орос томоохон өрсөлдөгч болж байна гэдгийг онцолсон. Энэ нь цаашид Оросын хилээр дамжих ачаалал улам нэмэгдэхийг л хэлж байгаа юм.

Тавантолгойгоос хил хүртэлх замынхаа концессыг хэн хийх үү гэж хэрэлдээд өдий хүрлээ шүү дээ. Шинэ зам тавина гээд зарчмын хувьд шийдсэн, концессоо байгуулчихсан ба шинэ нисэх онгоцны буудал руу зам тавьж байгааг Хятадын компани үргэлжлүүлж хийх юм байна. Энэ нь монголын Дарданговь гэдэг компанитай хамтарсан 360 сая долларын концесс бөгөөд 2020 он гэхэд дуусна гэж мэдэгдэж байгаа.

Төмөр замын концесс нь ахиад байгуулагдаагүй. Тавантолгойгоос зүүн Баян руу төмөр зам тавина гэнэ лээ. 460 км урт төмөр зам ба 1.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж байгаа. Бас нэг онцлог нь царигийн асуудлыг одоо хүртэл шийдээгүй байгаа гэж яриад байна. Хөндлөн төмөр замын царигийн асуудлыг шийдээгүй ба урдаас орж ирж байгаа экспортын зориулалттай



бол нарийн төмөр зам байна гэсэн бодлого гарсан байгаа хэдий ч зүүн Баянгаас урагш Ханги гэдэг газар руу шууд орох 260 км төмөр зам тавих гээд байгаа юм байна л даа.

Мэдээж нүүрсний бизнес бол үнэ нь өсч буурдаг мөчлөгтэй бизнес. Одоо үнэ нь нэлээд буугаад өсөх хандлагатай болоод эхэлсэн ба энэ нь 4,5 жил үргэлжилдэг процесс. Энэ хооронд бид замаа тавьж амжвал их хэмжээний нүүрс гаргах байх. Хятад улс өөрөө нүүрс хамгийн их авдаг, экспортлодог, хэрэглэдэг орон байгаа байхгүй юу. Ихэвчлэн Япон руу экспортлодог. Одоогийн 30 орчим сая тонн нүүрс гаргаж байгаа үзүүлэлт ойролцоогоор 50 орчим болно байх. Харин хүрэн нүүрсийг цахилгаан болгох, түлш болгох үйл явдал цаашид ч үргэлжилнэ гэж чуулганаар ярьж байна лээ. Газрын тосны үнэ өндөр бол нүүрсээрээ түлш гаргах нь ашигтай байдаг.

ЭТТ-н 30 хувийг гадаад дотоодын зах зээлд гаргана гэж байгаа дээр МУ-д ганц болохгүй

байгаа нь удирдлага. Сонгууль болоод өөр нам гарахаар удирдлагыг нь сольдог тул удирдлага нь улс төржүүлээд байдаг ийм компанийн 30 хувийг аваад юу бодож суух вэ гэдэг асуулт гарч ирээд байгаа юм л даа. Манай удирдлагууд өөрсдөд нь ашигтай биш бол хөдлөхгүй байгаа шүү дээ. Тиймээс яаралтай төмөр зам барьж, урагшаа гарч байгаа төмөр замаа нарийн гэдэг дээр тогтох хэрэгтэй байна. Болж өгвөл барьсан хүмүүс нь авсан хүмүүстэйгээ хамт гэрээ байгуулж, эрсдлийг нь үүрэх хэрэгтэй. Ингэхгүй бол бид баахан өр тавиад төмөр зам барьчихдаг, дараа нь Далай лам ирсэн байна гээд нүүрс авахгүй болчихвол хэцүү. Хятадтай холбосон бүх төмөр замаа нарийн, Оростой холбосон бүх төмөр

замаа өргөн болгоод дунд нь царигаас цариг руу шилжүүлэх ажлыг монголын компаниуд авбал асар том үйлчилгээний мөнгө бий болно. Хятад Орос 2 бол дэлхийн хамгийн том төмөр замуудтай ч хоорондоо 85 мм-ын зөрүүтэй байдаг. Бие биенийхээ стандартыг хүлээж авах боломжгүй том учраас дундаа сэлгэх ачаа тээврийн логистикийн төв байгуулах нь зүйтэй.

Коксжих нүүрсний угаах үйлдвэр байгуулах нь зүйтэй ч одоо байгаа 15 сая тоннын үйлдвэрээ бүгдийг нь ашиглаад дараа нь байгуулах замаар явах болов уу гэж хүлээж байна. Нүүрс бол МУ-ын экспортын 40 хувийг эзэлдэг тул нүүрсийг хурдан өндөр үнэ цэнээр зарах асуудал чухал.

DISCOVER MONGOLIA 2018

Нүүрсний салбарын Coal Mongolia чуулга уулзалтаас гадна уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдын бас нэгэн чуулга уулзалт болсон нь Discover Mongolia 2018 байлаа. Салбарын томоохон асуудлуудыг хамарч хэлэлцдэг уг уулзалтаар энэ жил 1. татвар, хууль эрх зүйн шинэчлэл, 2. хөрөнгө оруулалт ба сангууд 3. нийгмийн оролцоо гэсэн бүлэг сэдвүүд яригдлаа.

Энэ үйл ажиллагаа 16 дахь жилдээ болж байгаа юм. Үүний онцлог нь монгол дахь хөрөнгө оруулалт, уул уурхайтай холбоотой бүх хүмүүс оролцдог ба энэ удаа яам, бизнесийн зөвлөл, үндэсний уул уурхайн ассоциаци хамтарч зохион байгуулсан. Мөн монголд үйл ажиллагаагаа явуулдаг, хувьцаа нь дэлхийн хөрөнгийн бирж дээр байгаа бүх компани заавал ордог. Энэ утгаараа дэлхийн хөрөнгийн биржийг монголын уул уурхайтай холбосон гүүр болсон үйл ажиллагаа л даа.

Чуулганы нээлтэнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар хэлэхдээ “Уул уурхайн эдийн засаг дахь гүйцэтгэж байгаа үүргийг бид юугаар ч сольж чадахгүй, хэрвээ ямар нэг маягаар багасгах юм бол бид эдийн засгийн хямралд орчихдог гэдгээ мэдэж байгаа. 2017 онд уул уурхай МУ-ын экспортын 90 хувь, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 74 хувь, ДНБ-ий 22 хувь, гадаадын хөрөнгө оруулалтын 72 хувь байна. Уул уурхайгүйгээр монголчуудын ууж идэж байгаа зүйлийг төсөөлөхийн аргагүй болжээ” гэдгийг онцолсон. Мөн энэ оны эхний 7 сар гэхэд 26 сая тонн нүүрс гаргасан байгаа бөгөөд 765 мянган тонн зэсийн баяжмал, 9.2 тонн алт, 7.1 сая тонн төмрийн баяжмалыг МУ гаргаад байна гэдгийг хэлсэн.

ЭТТ компанийн 30 хувийг гаргах ажил нэлээд бэлтгэл сайтай яваад байгаа. Оюутолгой төслийн шалгалтууд байгаа ба ямар ч үйл ажиллагаанд нь саад болохгүйгээр урагшаа явуулна гэдгийг амлаж байна гэж хэлсэн. Цахилгаан станц, зэс хайлах



үйлдвэр баригдана, газрын тос боловсруулах үйлдвэр барина, дэд бүтэц байгуулна, 3 чиглэлд төмөр зам байгуулна, авто зам барина, хамгийн чухал нь Үндэсний баялагийн сангаа байгуулна гэж сайд мэдэгдэж байсан. Энэ бүхнийг хийхэд 2030 хүртэл 20 тэрбум доллар хэрэгтэй гэж тэмдэглэсэн.

Тогтвортой хөгжлийн бодлогод 2030 он гэхэд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 17.5 мянган доллар болно гэж байгаа ба одоо бол 3800 орчим доллар байгаа. 2040 он гэхэд МУ-ын хүн ам 4 сая болох юм байна лээ. Харин 2030 онд хүн ам ойролцоогоор 3.5 сая орчим байх ба энэ өсөлтийг хангахын тулд эдийн засаг 60 тэрбум байх ёстой буюу өнөөдрийнхөөс 6 дахин том байна. Төгрөгөөр ярьвал эдийн засаг өсөөд байгаа юм шиг хэрнээ доллараар ярьвал МУ-ын эдийн засаг 10 тэрбум дээр л гацаад байгаа юм даа. 10 тэрбумын эдийн засгийг 12 жилийн дараа 60 тэрбумын эдийн засаг болгохын тулд жил бүр 11.6 хувиар өсөх ёстой

юм байна гэсэн тооцоо гарсан. Энэ өсөлтийг уул уурхайгүйгээр төсөөлөх ямар ч арга байхгүй.

Энэ 2 чуулганыг нийлүүлээд хийсэн бол цаг зав, зардал хэмнэх байлаа.

Эрдэнэс Монголын 51 хувийг төр эзэмшдэг. Үүний дор бүх томоохон уул уурхайн компаниудыг оруулъя гэсэн юм байгаа л даа. Ингэвэл хэт данхар компани болох магадлал өндөр. Монголын компани том болохоор ерөнхий захирлыг нь булаацалдах тэмцэл хүчтэй болно байх. Эрдэнэс Монгол компанийн санхүү эрхэлсэн захирал Г.Ганболд гэдэг хүн эрдэс баялагийн бирж байгуулна гэж дээрээс ярьж байгаа. Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогыг 2014

онд баталсан. Үүндээ эрдэс баялагийн биржийг байгуулах зорилго, баримтлах зарчмыг тодорхой тусгасан байдаг юм байна лээ. Эрдэс баялагийн биржийг байгуулах хуулийн төслийг 2016 оны 6-р сард ЗГ хэлэлцсэн. Тэгээд үнэт цаасны зах зээлийн тухай болон, хөдөө аж ахуйн гаралтай бараа таваар түүхий эдийн биржийн тухай хуулиудыг бүрэн хэрэгжүүлж, зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүй гэдэг шалтгаанаар УИХ –д өргөн бариагүй байна.

Чуулганы үеэр “нинжа”-ны тухай яригдаагүй өнгөрсөн. Мөн татварын орчин баталгаажаагүй байгаа. Энэ хуулийг өөрчлөх гээд багц хуулийн санал гаргасан ч батлагдаагүй байна. Мөн байгаль орчны нөлөө буюу усны асуудлаар яриагүй.

БӨХИЙН ӨРГӨӨГ ТӨРД ШИЛЖҮҮЛЭХ ҮҮ

Монгол улсын Ерөнхийлөгч Х.Баттулга өнгөрсөн Пүрэв гарагт “Монгол бөхийн өргөөг төрийн өмчид шилжүүлэх” асуудлаар Ерөнхий сайдад албан бичиг хүргүүлсэн. Зарим хүмүүс энэ бол зөв шийдвэр. Төсвийн санхүүжилтээр барилгын ажлыг нь хийж дуусгасан юм бол төр өмчлөх нь зөв гэж байна. Төсвөөс гаргасан хөрөнгийн хэмжээ нь л гэхэд 70 гаруй хувь болж байгаа юм байна. Энэхүү төрийн өмчид шилжүүлэх тухай албан бичиг гарсны маргааш нь буюу Баасан гарагт Монголын Үндэсний Бөхийн Холбоо ТББ-аас мэдэгдэл гаргасан. Маргаантай асуудлыг гурван шатны шүүх нэгэнтээ эцэслэн шийдвэрлэсэн байхад энэ асуудлыг хөндөж төрд авах нь Үндсэн хуулийн зарчимд нийцэхгүй гэж мэдэгдсэн.

Төрийн үүрэг бол бүх төрлийн өмчийг хамгаалах ёстой болохоос биш өөрөө аваад байх ёстой биш л дээ. Өмч нь дотроо төрийн, нийтийн, хувийн гэх мэт ялгаатай байгаа. Монголын төрд дахиад нэг ордон хэрэгтэй юу гэдгийг сайн бодолцох хэрэгтэй. Төрийн бүх ордон алдагдалтай байгаа шүү дээ. Төрийн өмч байна гэдэг чинь нэг намын хүн очно, тэр хүн заавал алдагдалтай ажиллуулна. Тэгэхээр нь тэд нар төсөв мөнгөнөөс авна. Тийм шаардлага бид нарт байхгүй л гэж бодож байна. Шүүх маргааныг зохицуулж шийдвэр гаргах ёстой. Хамгийн зөв арга нь олон нийтийн хувьцаат компани болгоод л ТУЗ-тэй болгоод, ТУЗ нь ерөнхий захиралтай нь гэрээгээ хийгээд л, тэр



хэрэлдээд байгаа нөхдүүдэд хувьцааг нь худалдаж авах боломжийг нь өгөөд л шийдэж болно.



NEW NISSAN PATROL

9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0 %**

Хүү **1.4 %**

Хугацаа **84**сар


УРАМШУУЛАЛ:

- XPEL хамгааллын хууль
- Салбар сервисын эрх
- 4ш Өвлийн дугуй
- Салбарны шалны хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв

Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ АНГЛИ

➤ МОНГОЛ

➤ ЯПОН



GOOGLE STORE

APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com